ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022

amnesty.mn

Amnesty International Mongolia

Amnestymongolia

ГАРЧИГ

БИД ХЭН БЭ? 2

4 ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ

«ЗОРИГТОН» ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ 8

11 ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ

ЭРСДЭЛД БҮЙ ХҮВЬ ХҮМҮҮС 13

16 ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭХИЙН ТӨЛӨӨ 22

26 ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ЭМНЕСТИГИЙН ЗАЛУУЧУУД

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ 31

34 2022 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ

БИД ХЭН БЭ?

Нобелийн шагналт Олон Улсын Хүний Эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхий нийтийн томоохон хөдөлгөөн бөгөөд Монгол Улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнөөдөр Монгол Улсад 8000 гаруй гишүүн, дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн, мэргэжил, сонирхлын 25 бүлэгтэйгээр ажиллаж байна.

ГИШҮҮД, ДЭМЖИГЧИД



Гишүүд, дэмжигчдийг бүлгээр нь ангилбал:



БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА МОНГОЛ УЛСАД



Бүлэг, гишүүд бүхий аймаг

Үйл ажиллагаа хүрсэн аймаг

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДЭЛХИЙ ДАХИНД



УДИРДАХ ЗӨВЛӨЛ

С.Ганчимэг
Удирдах зөвлөлийн дарга

С.Очирбал
Удирдах зөвлөлийн дэд дарга

А.Отгончимэг
Санхүү хариуцсан гишүүн

Б.Болдсүрэн
ХЭБ хариуцсан гишүүн

Я.Мөнхчимэг
Кампанит ажил хариуцсан гишүүн

Б.Баялагмаа
Кампанит ажил хариуцсан гишүүн

Д.Оюунномин
Гишүүнчлэл хариуцсан гишүүн

Т.Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн

Б.Бадрал
Залуучууд хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

С.Очирбат
Хяналтын зөвлөлийн дарга

Б.Батцэцэг
Хяналтын зөвлөлийн гишүүн

М.Саруул-Эрдэнэ
Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО

Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирал

Г.Амарзаяа
Кампанит ажил хариуцсан зохицуулагч

П.Мөнхжаргал
Кампанит ажил хариуцсан зохицуулагч

У.Наранцацрал
Санхүүгийн ажилтан

Г.Сүхбат
Өсөлт, Хөгжил хариуцсан зохицуулагч

Я.Цэцэнзаяа
Залуучууд, активизм хариуцсан зохицуулагч

Б.Тэргэл
Залуучууд, активизм хариуцсан зохицуулагч

Б.Аззаяа
Ложистик, касс хариуцсан ажилтан 5 сараас

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ

ЗОРИЛТ

- *Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг бэхжүүлэх*
- *Бүх нийтийн тайван замаар хуран цугларах эрхийг баталгаажуулах*

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Эмнести Интернэшнлийн "Цар тахлын үед аюулд өртөөд буй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө" судалгааны тайланг 2 болон 5 дугаар сард "Ковид-19: мэдэх эрх, сэтгүүлчийн ёс зүй" сэдэвт форум болон "Эрсдэлийн мэдээллийн харилцаа" сэдэвт сургалт, семинарийн үеэр 21 аймгийн 9 дүүргийн арга зүйч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчид нийт 200 орчим хүнд танилцуулж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран чуулах эрхийг хамгаалахыг уриаллаа.

Монголын Эмнести Интернэшнл нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг 50 гаруй төрийн бус байгууллагын сайн дурын сүлжээ болох Хүний эрхийн ТББ-уудын Форумын гишүүн байгууллага бөгөөд 2022 онд тус Форумаас иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван замаар жагсах эрхийг хүндэтгэн хамгаалах, жагсаал цуглааныг тараахдаа хүч хэтрүүлэн хэрэглэсэн хэрэгт хариуцлага тооцох, иргэний орон зайг хумьсан, хүний эрхийг дордуулсан зүйл заалт бүхий хуулийн төслийг эргүүлэн татахыг шаардсан мэдэгдлийг гаргахад нэгдэж, дэмжин оролцлоо.

3 дугаар сард Эмнести Интернэшнлийн дэлхийн хүний эрхийн төлөв байдал танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулж, АНУ, ОХУ, Европын Холбоо зэрэг Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, ЦЕГ, прокурор, тагнуул зэрэг төрийн байгууллагууд, хүний эрхийн идэвхтнүүд, их дээд сургуулийн судлаачид, багш, оюутнууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, иргэд 50 гаруй хүн оролцлоо.

Сэтгүүлчдэд зориулсан сургалтын үеэр



Эмнести Интернэшнлийн дэлхийн хүний эрхийн төлөв байдал 2021/22 тайланд Монгол улсад Ковид цар тахлын үед тайван замаар жагсах эрхийг хязгаарласан, эрхийнхээ төлөө тэмцэж жагссан эрүүл мэндийн ажилтнуудыг сүрдүүлсэн, хүрээлэн буй орчны асуудлаар ажилладаг хүний эрхийн идэвхтнүүд, ЛГБТИ хүмүүс заналхийлэлд өртснийг онцолсон. Мөн эрүүдэн шүүсэн хэрэгт хариуцлага тооцдоггүй байдал үргэлжилсээр, хот дахин төлөвлөлтийн хэрэгжилтэд иргэдийн бодит оролцоог хангаж чадахгүй байгаа ба хотын захын хорооллын зурагтгүй, интернэтийн сүлжээгүй газрын хүүхдүүдийн сурч боловсрох эрх зөрчигдсөн асуудлыг багтаажээ.

12 сарын 6-ны жагсаалын ажиглалт

БҮХ НИЙТИЙН ТАЙВАН ЗАМААР ЖАГСАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Монгол улсад 4-р сард болсон залуучуудын жагсаал цуглааны асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комисстой уулзаж, жагсаал, цуглааны үеэр хүч хэтрүүлэн хэрэглэсэн, үндэслэлгүйгээр баривчилсан асуудлаар хяналт шалгалт хийхийг уриаллаа.

Монголын Эмнести Интернэшнлээс Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран 4 дүгээр сарын 28-29-нд Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хуран чуулах эрхийг бэхжүүлэх кампанит ажлын хүрээнд "Жагсаал цуглааны ажиглагч бэлтгэх" сургалтыг 3 удаа зохион байгуулж, иргэний нийгэм, ХЭҮК-ын орон нутгийн болон бусад ажилтнууд, өмгөөлөгчид, хүний эрхийн идэвхтнүүдийг хамруулаа.

Хаврын жагсаалын ажиглалт

12 сарын 10-ны жагсаалын ажиглалт

2022 оны 12-р сард өрнөсөн жагсаал цуглааны үеэр Монголын Эмнести Интернэшнлийн ажилтан, гишүүд, ТББ-ын Форумын гишүүн байгууллагууд, мөн ХЭҮК-ын ажилтнуудын хамтаар аливаа хүний эрхийн зөрчил, тохиолдлоос сэргийлэх, баримтжуулах зорилгоор тус жагсаалын үеэр ажиглалт хийлээ.

Жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахдаа олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хангаж ажиллах талаарх цагдаагийн алба хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн Ерөнхий Газартай уулзалт хийв. Тус уулзалтаар цаашид жагсаал цуглааны үеэр хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд хэв журам сахиулах талаарх олон улсын хэм хэмжээг тусгасан сургалтын модуль гаргаж, холбогдох цагдаагийн алба хаагч, удирдах албан тушаалтнуудад тогтмол сургалт явуулахад анхааран хамтарч ажиллахаар боллоо. Энэ хүрээнд 9 дүгээр сард ХЭҮК-оос Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтарч "Жагсаал цуглааны үед хууль сахиулахад хүний эрхийг хангах нь" сургалтыг цагдаагийн алба хаагч, удирдах албан тушаалтнуудад явууллаа.

Монголын Эмнести Интернэшнлээс эрх баригч нарт хандан Монгол улсын олон улсын гэрээгээр хүлээсэн тайван замаар жагсах эрхийг хүндэтгэн хамгаалж, хангах үүргийг нь сануулж, Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцээгүй байдлаар аливаа хязгаарлалт тогтоохгүй байх, гуравдагч этгээдийн зүгээс учруулж болзошгүй аливаа хүчирхийллээс жагсагчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авах, тайван замаар эсэргүүцлээ илэрхийлэх эрхээ бүрэн хэрэгжүүлэх боломжит орчин нөхцлийг бий болгож, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар жагсах, цуглах эрхийг баталгаажуулах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг шаардлаа.

ЦАР ТАХАЛ БА ЦАГДААГИЙН ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГАА

Монголын Эмнести Интернэшнлээс Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгээр 2021 онд цар тахлын үеийн цагдаагийн хууль сахиулах ажиллагаанд мониторинг хийж, 2022 оны 5 дугаар сард *"Ковид-19 цар тахал ба хууль сахиулах ажиллагаа: цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол"* судалгааны тайланг эмхтгэн гаргаж, вэб сайт, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж олон нийтийн хүртээл болголоо. Тайланд дурдагдсан хүний эрхийн зөрчил,

Жагсаал цуглааны үеэрх ХЭҮК-той хийсэн уулзалт

ЭИ-ийн дэлхийн хүний эрхийн төлөв байдал 2021/22/ тайлангийн үеэр

тохиолдлуудад анхаарал хандуулж, цаашид ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хангаж, хамгаалах үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхийг шаардсан зөвлөмжүүдийг эмхтгэн гаргаж, тайлангийн хамт холбогдох албан тушаалтан, хууль тогтоогчдод хүргэлээ. Энэ хүрээнд ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албатай уулзалт хийж, УИХ-ын гишүүд, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, иргэний нийгэм, Нийслэлийн засаг даргын тамгын газар болон бусад холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, хуульчидтай уулзалт хийн, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, хэвлэлийн бага хурлаар дамжуулан олон нийтэд түгээлээ.

Уг судалгааны тайланд Монгол улсад олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн хууль, бодлого хэрэгжиж байгааг, цагдаагийн байгууллага, алба хаагчдын зүгээс иргэдийн тайван жагсаал цуглааныг хууль бусаар албадан тараасан, зохион байгуулагчид болон оролцогчдыг үндэслэлгүйгээр баривчилж, цагдан хорьсон, хүч хэтрүүлэн хэрэглэсэн, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцсан, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийг олон нийтийн хэрэгслээр дэлгэж, ялгаварлан гадуурхагдах нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг зөрчлийг баримтжууллаа.

Мониторингийн дүгнэлтэд үндэслэн МЭИ-ээс хууль тогтоогчид, засгийн газарт хандан гаргасан зөвлөмжүүдээс тоймлон дурдвал:

Хууль сахиулах байгууллага, алба хаагчдын гамшгийн үед ажиллах чиг үүрэг, хариуцлагыг тодорхой зохицуулсан хууль, журмыг олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээ, НҮБ болон бусад хүний эрхийн байгууллагаас өгч буй зөвлөмжид нийцүүлэн батлах;

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулах;

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтан, алба хаагчдад аливаа үйл ажиллагаандаа хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, зарчмыг баримтлан ажиллах талаар шинэчилсэн сургалтыг тогтмол явуулах;

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах онцгой нөхцөл байдлыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх зэрэг Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах арга хэрэгсэл болгон ашиглахгүй байх;

Нийгмийн эрүүл мэндийн хямралыг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бүсдын эрх, эрх чөлөөг зөрчиж, ашиг сонирхолд нь хууль бусаар халдсан бол нийтийн хэв журам хамгаалах үүрэг хүлээсэн төрийн байгууллага болон холбогдох албан тушаалтнуудад зохих хууль ёсны хариуцлагыг зайлшгүй хүлээлгэдэг байх.

ЦЕГ-тай хийсэн нөлөөллийн уулзалт

Цар тахал ба цагдаагийн хууль сахиулах ажиллагаа тайлангийн зөвлөмжийг талуудад танилцуулах уулзалт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлд заасанчлан Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй. Шударгаар шүүлгэх эрх нь мөрдөн байцаах, баривчлах, цагдан хорих, түүнчлэн шүүх ажиллагааны өмнөх үеийн ажиллагаа, шүүх хуралдаан, давж заалдах шат, яллах болон ял эдлүүлэх зэрэг бүхий л үе шатанд хэрэгжих ёстой.

3 дугаар сард Хэвлэлийн хүрээлэн, Өмгөөллийн "Эрх зүйн гүүр" хуулийн фирмтэй хамтран "Шударгаар шүүгдэх эрх хэрэгжиж байна уу"? сэдэвт бодлогын мэтгэлцээн зохион байгууллаа. Мэтгэлцэгч талуудын зүгээс хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд авсан гэрчийн мэдүүлгийг дараа нь сэжигтэн яллагдагч болгон байцаахдаа үндэслэл болгож хэрэгт холбогдсон хүнийг буруутгах тохиолдол их байгааг онцоллоо. Мөн сэжигтэн, ялтныг баривчлан саатуулахдаа ар гэрийнхэнд нь мэдэгдэхгүй, өмгөөлөгчид нь үндэслэлийг нь тайлбарладаггүй, мэдүүлэг, нотлох баримтыг үзүүлдэггүй нь тухайн иргэний халдашгүй байдал, шударгаар шүүгдэх эрхийг зөрчиж байгааг дурдлаа. Шүүхийн шатанд шүүгч, прокурор, өмгөөлөгч нарын дунд адил тэгш мэтгэлцэх боломж хангалтгүй, ялангуяа өмгөөлөгч прокуророос асуулт асуух эрхгүй байгаа нь шударгаар шүүгдэх эрхэд ноцтой хохирол учруулж байгааг мөн онцоллоо.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ

ЗОРИЛТ

- *Хүний эрх хамгаалагчийг таниулан хамгаалах, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шаардах*
- *Хүн бүр хүний эрхийг дээдэлдэг дэлхий ертөнцийг бүтээхэд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх*

Хүрээлэн буй орчин, газар шороо, орон байртай байх эрх, шударгаар шүүлгэх эрх зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалж тайван замаар тэмцэж, үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэн, засгийн газар, хууль тогтоогч нарт хандсан нөлөөллийн болон олон нийтэд танин мэдүүлэх төрөл бүрийн үйл ажиллагааг дангаараа болон бусадтай хамтран зохион байгуулж, тэмцэж буй тэдгээр хүмүүсийг **хүний эрх хамгаалагч** хэмээн дэлхий дахинаа тунхагласан. Хүний эрх хамгаалагчид нийгмийн бүхий л давхаргыг төлөөлдөг. Тэдний дунд оюутан, орон нутгийн удирдагч, сэтгүүлч, хуульч, хүний эрхийн зөрчлийн хохирогчид, гэр бүлийнхэн нь, эмнэлгийн ажилтан, багш, үйлдвэрчний эвлэлийн гишүүн, шүгэл үлээгч, байгаль хамгаалагч гэхэд олон төрлийн мэргэжлийн хүмүүс байдаг.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙГ ХАМГААЛАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1 дүгээр сарын 31 буюу Иргэний нийгмийн өдрөөр хүний эрхийн ТББ-ын Форумын гишүүн байгууллагуудтай хамтран Хэвлэлийн бага хурал зохион байгуулж, төрөөс иргэний нийгмийн үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлийг нь хязгаарлах, хориглох агуулгатай хууль тогтоомжийн төслийг хэлэлцэж байгаад санаа зовниж байгаагаа илэрхийлж, УИХ-ын даргад шаардлага хүргүүллээ.

Иргэний нийгмийн орон зай, ТББ-уудын хууль ёсны үйл ажиллагааг хумьсан Холбооны эрх зүйн байдлын тухай болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг буцаан татахыг хууль санаачлагчдаас шаардаж, хүний эрхийг хангаж хамгаалахад хувь нэмэр оруулж буй иргэний нийгмийн байгууллагуудад бие даан хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн таатай орчин нөхцөл бий болгохыг уриалсан уриалгыг УИХ-ын 76 гишүүнд хүргүүлэв.

Хүний эрхийн ТББ-ын Форум (Форум)-ын гишүүн байгууллагууд, ТББ-ын Консорциумын хамтаар иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах, ТББ-ын хуулийг шинэчлэн сайжруулах чиглэлээр хууль тогтоогчид, Хууль зүй дотоод хэргийн яам болон бусад холбогдох албан тушаалтнуудтай нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулаа.

Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан ХЭҮК-ын гишүүнд нэр дэвшигчийг сонсох нээлттэй сонсголд оролцож, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх



Жагсаал цуглаан ба хүний эрхийн ажиглалт сургалт

механизмын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Форумын байгуулагуудтай хамтран хүний эрх хамгаалагчийн эрсдэлийн журам боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан гишүүнд хүлээлгэн өгөхөөс гадна Форумын дэргэдэх хүний эрхийг хөхиүлэн дэмжих, эрсдэлд буй хүний эрх хамгаалагчдад туслах Тусгай төсвийн ажлын хэсэгт орж ажиллан хариуцлагагүй уул уурхайн буруутай үйл ажиллагааг эсэргүүцэж, байгаль орчныг хамгаалсныхаа төлөө эрх нь зөрчигдсөн хүний эрх хамгаалагчдад тусламж үзүүллээ.

9 дүгээр сард Хүний эрхийн төлөөх олон улсын үйлчилгээ байгууллагатай Монгол улс дахь хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар уулзалт хийж, хүний эрх хамгаалагч нарт тулгарч буй бэрхшээлийн талаар хуваалцав.

Хүний эрх хамгаалагч залуучуудыг зуны зуслан сургалт

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ТАНИУЛАН ХАМГААЛАХ, ЗАЛУУЧУУДЫН ИДЭВХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ:

7 дугаар сард “Залуу хүний эрх хамгаалагч” зуны зуслан сургалтыг зохион байгуулж, орон нутаг, нийслэлийн 23 идэвхтэн залуучуудыг хамруулж, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр идэвхтэн залуучуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. Сургалтад хамрагдсан залуу идэвхтнүүд хүний эрх хамгаалагч, уур амьсгалын өөрчлөлт, эрүүдэн шүүхээс ангид байх эрх, шаардлагатай орон байраар хангагдах эрхийн талаар олж авсан мэдлэг ойлголтдоо тулгуурлан хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зурагт мэдээлэл, видео контентуудыг сошиалаар түгээж, хууль тогтоогчид, эрх баригчдаас хүний эрхийг хангаж ажиллахыг шаардсан уриалга, шаардлагуудад нэгдлээ.

Монголын Эмнести Интернэшнлийн **25** багш, хуульч, өмгөөлөгч, оюутан залуучууд идэвхтэн дэмжигчдийг “Хүний эрх хамгаалагч” сургагч багшаар бэлтгэв.

6 дугаар сард Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны **65** орчим удирдах албан тушаалтнуудын хүний эрх хамгаалагч, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулав.

«ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ЗОРИГТОН» ХӨРӨГ НАЙРУУЛЛЫН УРАЛДААН

Хүний эрх хамгаалагчдыг таниулан хамгаалах зорилгоор 4 дэх жилдээ зохион байгуулагдсан хөрөг найруулын уралдааныг 11 сарын 29 буюу Эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг хамгаалах олон улсын өдрийг угтан ХЭҮК, Монголын Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Монголын Эмэгтэйчүүдийн сан, Оюу толгойн хяналт ТББ-уудтай хамтран "Эмэгтэй хүний эрх хамгаалагч Зоригтон" сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Хүний эрх хамгаалагчийн тухай мэдлэг ойлголтыг өгөх, мультмедиа бүтээлийг тайлбарлах сургалтыг танхимаар болон цахимаар, хүний эрх хамгаалагчийн нэг өдөртэй танилцах семинарыг тус тус зохион байгууллаа. Сэтгүүлзүйн мультмедиа төрлөөр зохион байгуулагдсан уг уралдаанд хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгаль орчин, малчдын эрхийн асуудлаар ажиллаж байгаа хүний эрх хамгаалагчдын түүхийг өгүүлсэн 19 бүтээлийг хүлээн авч, вэб сайт, сошиал сүлжээгээр дамжууллаа.

Дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихээр тэргүүн шугамд тэмцэж байгаа хүний эрх хамгаалагчид, ялангуяа эмэгтэй хамгаалагчид өдөр тутамдаа айлган сүрдүүлэлт, заналхийлэлтэй тулгарсаар байгаа нь тэдэнд төрийн хамгаалалт хэрэгтэй байгааг харуулдаг. Эмэгтэй хүний эрх хамгаалагчдыг онцолсон энэ жилийн уралдааны тэргүүн байрыг "Чимээгүй Зоригтон" бүтээлээр www.gogo.mn сайтын хамт олон, дэд байрыг "Маргаашийн нарыг харах эсэхээ мэдэхгүй гэрээслэл бичээд суусан үе бий" бүтээлээр сэтгүүлч Г.Нямсүрэн, С.Уянга нар, гутгаар байрыг "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалагч зогсошгүй хүч" бүтээлээр NTV телевизийн баг хамт олон тус бүр эзэлсэн байна. Тус уралдаанд ирүүлж байгаа бүтээлүүд жил ирэх тусам чансаатай, өрсөлдөөнтэй болж байгаа бөгөөд энэ жил бид нэмж Тусгай байрын 2 шагналыг З.Энхбаяр, Б.Батчимэг нарын "Амиар дэнсэлгэх тэгш эрх", Ийгл ТВ-ийн сэтгүүлчид О.Эрдэнэчимэг, М.Наранзаяа нарын "Гэрээсээ гараад ир гэрэл байна" бүтээлүүдэд олголоо.

300 000

Хүний эрх хамгаалагчдыг таниулан хамгаалах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, иргэний нийгэм, хүний эрхийн ТББ-уудын хараат бусаар бие даан үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг бий олгох чиглэлээр гаргасан зурагт хуудас, захидал уриалга, мэдээ мэдээлэл, Хэвлэлийн бага хурал, сайт, ТВ ярилцлага, мэдээнүүд наад зах нь 300 000 хүнд хүрлээ.

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ

ЗОРИЛТ

- *Монгол улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын дагуу үр нөлөө бүхий Үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулахад нөлөөлөх*
- *Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааг хориглохыг шаардах*

ХЭҮК-ын гишүүнтэй уулзаж, эрүүдэн шүүх, зүй бус харьцаатай холбоотой өргөдөл гомдлуудад анхаарал хандуулан ажиллахыг урриаллаа. ХЭҮК-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа хариуцсан гишүүнд нэр дэвшигчдийг сонсох нээлттэй сонсголд оролцлоо.

Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос санаачилсан "Өмгөөллийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" шилдэг илтгэлийн уралдаан шалгаруулах арга хэмжээг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Монголын Олон Улсын Арбитр, Чимид сан, Монголын Хуульчдын холбоо, Өмгөөллийн "Ананд адвокатс" ХХН, Өмгөөллийн "Монгол Илч" ХХН, Өмгөөллийн "Монгол Өмгөөлөгч" ХХН зэрэг байгууллагатай хамтран 6 дугаар сард зохион байгуулав. Өмгөөлөгчдийн практикт тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой тус илтгэлийн уралдаанд эрдэмтэн, судлаач, багш, хуульч, өмгөөлөгч, практик ажилтнаас 14 илтгэл,

хууль зүйн их, дээд сургуулийн оюутнаас 5 илтгэл ирүүлснээс судлаач болон оюутан гэсэн 2 төрлөөр шалгаруулалт явагдлаа. Мөн энэ үеэр Монголын Эмнести Интернэшнлээс тус байгууллагын анхны гишүүдийн нэг, Хуульчдын бүлгийн ахлагч байсан академич Ж.Амарсанаад хүндэтгэл үзүүлэв.

Эрүүдэн шүүхийн хохирогсдод туслах олон улсын өдрийг угтан ХЭҮК, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмаас санаачлан 6 дугаар сард шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд, их дээд сургуулиуд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудын хүрээнд зохион байгуулсан мөрдөн шалгах, мэдээлэл

НҮБ-ын ХЭДКГ-ын төлөөлөгчтэй хийсэн уулзалт

ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмтай хийсэн уулзалт

цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх "Мендезийн зарчим"-ыг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт илтгэл тавьж, хамтран зохион байгууллаа.

Хууль ёсны зорилгоосоо гадуур байнга буруугаар ашиглагддаг гав, бороохой, нулимс асгаруулагч хий, резинэн сум зэрэг цагдаагийн стандарт хэрэгсэл буюу эрүүдэн шүүх, бусад хэрцгий харьцаанд хэрэглэгдэж болзошгүй хууль сахиулах байгууллагын тусгай хэрэгслийн дэлхий даяарх худалдаанд хатуу хяналт бий болгохыг Эмнести Интернэшнл бусад байгууллагуудын хамтаар шаардаж байгаа юм. Тэгвэл НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас эрүүдэн шүүх тусгай хэрэгслийн худалдааг хориглох асуудлаар улс орнуудад хуулиар үүрэг хүлээлгэх санаачилга гаргасныг Эмнести Интернэшнл нь талархан хүлээн авлаа. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас эрүүдэн шүүх хэрэгслийн худалдааг таслан зогсоохын тулд хуулиар үүрэг хүлээлгэх гэрээ бий болгох асуудлаар санаачилгатай ажиллаж байгаад талархсан Хэвлэлийн мэдээг Эрүүдэн шүүхийн хохирогсдод туслах олон улсын өдрийг угтан Эмнести Интернэшнлээс гаргалаа.

9 дүгээр сард ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм хариуцсан гишүүн, тус хэлтсийн мэргэжилтнүүдтэй нөлөөллийн уулзалт хийж, Монгол улсад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тус механизмыг чадавхжуулах талаар санал солилцов.

10, 11 дүгээр сард НҮБ-ын Дур зоргоор баривчлан саатуулах асуудлаарх Ажлын хэсгийн гишүүд болон НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын албаны Монгол Улсыг хариуцсан ажилтан Себастьен Гиёогтэй Монголын Эмнести Интернэшнл уулзалт хийж, Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдал, ялангуяа эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн хэрэгжилтэд анхаарал хандуулж хорих, цагдан хорих газарт хяналт шалгалт хийх, мөн иргэний нийгмийн орон зайг хумьсан хуулийн төслүүдэд анхаарал хандуулахыг уриаллаа.

Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн хүсэлтээр тус ангийн 40 орчим алба хаагчдад хүний эрх, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн чиглэлээр сургалт зохион байгуулав.

10 000 ОРЧИМ

Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зурагт хуудас, мэдээ мэдээлэл сошиал контентууд 10 000 орчим хүнд хүрлээ.

ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮМҮҮС

ЗОРИЛТ

- *Эрсдэлд буй хувь хүн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх,*
- *Гишүүд дэмжигчдийг идэвхжүүлэх,*

Эрхийнхээ төлөө бичицгээе

ТАНЫ ҮГ ХҮЧТЭЙ

Эрхийнхээ төлөө бичицгээе аяны үеэр илгээсэн таны үг, захидал, үйл ажиллагаа шийдвэр гаргагч нарт нөлөөлж, засгийн газрууд эрүүдэн шүүгчидтэй хариуцлага тооцож, үзэл санааны хоригдлуудыг суллаж, илүү олон хүнд эрх чөлөөгөө олж авахад нь тусалдаг.

Өмнөд Судан улсад цаазын ял сонссон дунд сургуулийн сурагч байсан Магайн төлөө 2019 оны "Эрхийнхээ төлөө бичицгээе" аянаар 700,000 гаруй захидал уриалга илгээсний үр дүнд 2022 оны 3-р сард Дээд шүүхээс түүнийг хэрэг гарах үед насанд хүрээгүй байсан гэдгийг хүлээн зөвшөөрч, сулласан юм. Магай одоо хилийн чанадад амьдарч байгаа ба өөртэй нь адил нөхцөлд орсон хүмүүст туслахаар ажиллаж байна.

Багш мэргэжилтэй Бернардо Каал Хол Гватемалын хойд хэсэгт орших Кахабон голын усан цахилгаан станцын төсөлд нэрвэгдсэн иргэдийг хамгаалахын тулд хичээнгүйлэн зүтгэсэн. 2018 оны 11-р сард түүнд хилс хэргээр долоон жилийн хорих ял оногдуулжээ. 2021 оны Эрхийнхээ төлөө бичицгээе аяны үеэр Бернардогийн төлөө 500 000 гаруй захидал уриалга, үйл ажиллагаа өрнүүлсэн ба түүнийг 2022 оны 3-р сард сулласан байна.

Эрхийнхээ төлөө бичицгээе

ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ АЯН:

Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан дэлхийн 150 орчим улс, газар нутагт Эрхийнхээ төлөө бичицгээе аян өрнөж, Бангладеш, Камерун, Франц, Парагвай, Куба, Орос, Морокко, Зимбабве, Иран, Хонг Конг улсад үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдэлснийхээ улмаас эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн төлөө захидал бичих, гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулаа.
Тус аянд МЭИ-ийн эмэгтэйчүүд, багш, оюутан, залуучууд, сурагчид, 5 орон нутгийн бүлгүүд идэвхтэй оролцож, их дээд сургууль, ЕБС, Хүүхдийн урлан бүтээх төв, сайн дурынхны чуулган зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр захидал уриалгын аян өрнүүлж, нийт 23 000 орчим гарын үсэг цуглуулж, илгээлээ.

Мөн аяны үеэр Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид УИХ-ын дарга Г.Занданшатар, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт хандан Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар хуран чуулах, эвлэлдэн нэгдэх эрхийн талаарх олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн найруулах, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг буцаан татахыг уриалсан захидал уриалгад нийт 3400 орчим гарын үсэг цуглуулж илгээлээ. Цаашид аливаа хуулийн төслүүдийг боловсруулахдаа иргэд олон нийт, иргэний нийгмийг өргөн хүрээнд бодитоор хамруулан олон талын оролцоог хангах, иргэний орон зайг хумих аливаа оролдлого гаргахгүй байхыг шаардлаа.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ

ЗОРИЛТ

- *Татвар, өрийн дарамт, төсвийн хэмнэлт, нийгмийн хамгааллын бодлогоос үүсч буй ялгаварлан гадуурхалтыг бууруулах*
- *Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, Эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хамгааллын эрхийг бэхжүүлэх*
- *Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас эрх, ашиг нь зөрчигдөж буй болон зөрчигдөх өндөр эрсдэлтэй бүлгүүд, малчдын дуу хоолойг нэмэгдүүлэх*
- *Шударга бус татвар, өрийн дарамт, төсвийн хэмнэлтийн улмаас ялгаварлан гадуурхагдсан хувь хүн, хамт олны дуу хоолой, үйл ажиллагааг нэмэгдүүлэх*

1. ТАТВАР, ТӨСӨВ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДЛААР:

Шударга бус татвар, өрийн дарамт, төсвийн хэмнэлт, нийгмийн хамгааллын асуудал нь Эмнести Интернэшнлийн анхаарлын төвд орж буй шинэ тулгамдсан сэдэв тул 2022-2028 оны Стратегийн нэгдүгээр үе шатанд Монголын Эмнести Интернэшнл нь бэлтгэл хангах, чадавх бий болгоход чиглэсэн ажлаа үргэлжлүүлэв.

"Төсвийн хэмнэлт ба хүний эрх"-ийн асуудлыг эрүүл мэндийн салбарын жишээгээр тайлбарлах, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудад илтгэл тавих, танилцуулга хийх, "Төсөв ба Хүний эрх" цуврал танилцуулгыг олон нийтэд түгээх зэргээр нөлөөлөл, соён гэгээрлийн ажилд анхаарал хандуулж ажиллав. Ингэснээр иргэд нийгмийн сүлжээнд төсвийн асуудлаар дуу хоолойгоо өргөх нь эрчимжлээ. Иргэдийн дуу хоолой, бидний нөлөөллийн ажлын үр дүнд цөөн боловч төрийн холбогдох зарим байгууллага хүний эрхэд ээлтэй төсөв боловсруулах, төсөв төлөвлөх явцдаа иргэдээс санал авах зэрэг ажлыг цахим, цахим бус хэлбэрээр зохион байгуулж эхэллээ.

Хүний эрх ба төсөв, татвар ба нийгмийн хамгааллын бодлогын асуудлаарх Эмнести Интернэшнлийн тайланг гишүүд дэмжигчдэдээ танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулж, Удирдах болон Хяналтын зөвлөл, орон нутгийн 8 бүлэг, мэргэжил сонирхлын 7 бүлгийн гишүүд идэвхтэй оролцов. Хэлэлцүүлгээр төсөв, татвар нь хэрхэн хүний эрх тэр дундаа, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахтай холбогдож буйг ойлгосноор төсөв, татварын асуудал нь байнга анхаарах, хянах ёстой зүйлийн нэг гэдэгтэй санал нэгдэв. Монгол улс дахь төсвийн хэмнэлтийн бодлого, нийгмийн хамгаалал, оновчгүй тогтолцооны талаар судлах, судалгаанд үндэслэн олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах нь ядуурлыг бууруулж, ялгаварлан гадуурхалтыг багасгахад хувь нэмэр болно гэж үзээд гишүүд энэ чиглэлд мэдээлэл түгээх аянд нэгдлээ. Төсөвтэй холбоотой постер, мэдээлэл цахим болон цахим бус орчинд давтагдсан тоогоор нийт 44000 орчим хүнд хүрсэн байна.

2. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах "Төр үүргээ мэд, биелүүл" кампанит ажлаараа "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль" болон түүнийг дагалдан гарсан журмуудад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хүний эрхийн хамгаалалт бий болгох, эрхээ хамгаалж чаддаг иргэдийн хүчирхэг бүлгүүд бий болгохыг зорьж ажиллав.

Гэр хорооллын дахин төлөвлөлт эрчимжсэн ХУД-ийн Яармаг орчмын 5, 8-р хорооны иргэд болон БЗД-ийн 23-р хорооны иргэд нийт 35 хүнд орон байртай байх эрхийн сургалт хийж, тэд цааш нь тус тусын хороондоо мэдээлэл түгээсэн. БЗД-ийн 10-р хорооны Хангамжийн 27 айлын дахин төлөвлөлттэй холбоотой гомдлын мөрөөр ХЭҮК-оос зохион байгуулсан сонсголд гэр хорооллын дахин төлөвлөлтөөс үүдэн хүний эрх зөрчигдөж байгаа өнгөрсөн болон өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийж оролцсон, ХЭҮК-ын захиалгаар хийж буй Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хууль эрх зүйн орчны талаарх судалгаанд мэдээлэл өгсөн, БХБЯ-наас Гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар судалж буй судалгааны багт мэдээлэл өгсөн зэрэг нь бидний зүгээс орон байртай байх эрхийн зөрчлийг бууруулах, эрх зүйн орчныг сайжруулах цаашдын үйлсэд эх сурвалж, мэдээллээр хангагчийн үүргээр оролцов.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон НҮБ-ын суурин зохицуулагчийн газраас зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн зорилт - 2030-ын хэрэгжилт" олон нийтийн өдөрлөгт Гэр хорооллын дахин төлөвлөлтөд хуулийн хамгаалалтыг шаардсан ил захидалд иргэд, олон нийтээр гарын үсэг зуруулах зэргээр орон байртай байх эрхийг хамгаалахыг шаардсан жил болов.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалах зорилготой "ОББЭ-Эрх зүйн хөтөч" төсөл хэрэгжүүллээ.Төслийн хүрээнд "Орон байртай байх эрх"-ийн эрх зүйн хөтөч бэлтгэх 4 сургалтыг Завхан, Архангай аймаг болон нийслэлд тус тус зохион байгуулж 85 хүн бэлтгэсэн бөгөөд тэднийг чадавхжуулах цахим болон танхимын 3 сургалт хийсэн. Эрх зүйн хөтөч нарт зориулсан орон байртай байх эрх, Хүүхдийн эрх ба Гэр бүлийн хүчирхийлэл болон цахимд суралцах нь сэдэвтэй чадавх бэхжүүлэх сургалтын 13 видео бичлэг хийлээ. "Орон байртай байх эрх"-ийн эрх зүйн хөтчийн давтан сургалтад хамрагдан, иргэдэд мэдээлэл, зөвлөгөө тогтмол өгдөг 25 эрх зүйн хөтчид Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс "Эрх зүйн хөтөч"-ийн гэрчилгээ олгосон.

Явуулын эрх зүйн хөтөч нар СХД, БЗД, ХУД, ЧД, СБД-ийн нийт 24 хорооны иргэдэд гэрээр биечлэн болон цахимаар сургалт, мэдээлэл, зөвлөгөө өглөө. Бид эрх зүйн хөтөч нараар дамжуулан 61000 гаруй хүнд 2013 оноос хойш хэрэгжсэн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хүрч шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн зөрчлийн талаар мэдээлэл түгээж, эрхээ хэрхэн хамгаалах, тулгамдаж буй асуудлаа хэрхэн

шийдвэрлүүлэх талаар анхан шатны хууль, эрх зүйн тусламж зөвлөгөө өгсөн. Өдөр тутмын хэвлэл мэдээлэл, цахим сонин видео, аудио контент, шууд хэлэлцүүлэг, сургалтын видео бичлэг, комик болон эрх зүйн хөтөч нарын хөтлөн явуулдаг Фэйсбүүк хуудсаар дамжуулан 590000 гаруй хүнд хүний эрхийн мэдээлэл өгчээ. Түүнчлэн 4 ном, гарын авлага, холбогдох хууль, тогтоомжийн тайлбар бүхий 18 бичил видео болон 7 подкаст ярилцлага бэлдэн олон нийтэд түгээв.

Завхан аймгийн Улиастай хот, БЗД-ийн 12 хороо – Амгалан, Чулуун овоо болон ХУД-ийн Яармагийн 5 дугаар хороонд "Эрх зүйн хөтчийн байнгын цэг" байгуулж, нийт 17 эрх зүйн хөтөч тогтмол ажиллаж байна. Архангай, Завхан аймгийн орон нутгийн телевиз, радио, сонинууд эрх зүйн хөтчийн байнгын цэгийн талаар мэдээлэн орон нутгийн иргэдэд хүрэх боломжийг бүрдүүллээ. МЭИ-ийн болон "Эрх зүйн хөтөч нар – орон байртай байх эрх, нүүлгэн шилжүүлэлт" цахим хуудас, подкаст, хөрөг найруулын уралдаанаар эрх зүйн хөтчийн, хийж буй ажлыг тогтмол танилцуулж нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд болон зорилтот бүлэгт хүргэв.

MNB world нэвтрүүлгээр орон байртай байх эрхийн эрх зүйн хөтөч Б.Бадралын талаар тусгай нэвтрүүлэг гарсан. Generation | Youth board member of Amnesty International Mongolia, Badral Boldbaatar | MNB World.

Дахин төлөвлөлтөд өртөж хохирсон болон хохирч болзошгүй зорилтот бүлгийн иргэд мэдээлэл авч, өөр хоорондоо туршлага солилцох сургалт, уулзалт хэлэлцүүлгийн явцад эвлэлдэн нэгдэж "Дахин төлөвлөлт, иргэдийн оролцоо эвсэл" байгуулагдлаа. Ингэснээр дахин төлөвлөлтөд хамрагдсан газрын иргэд, ТББ-уудын чадавх, оролцоо нэмэгдаж, хамтарч хэвлэлийн бага хурал хийх, тайван жагсах, хамтарсан мэдэгдэл хийх, хамтдаа албан бичиг илгээх зэргээр төрөөс зөрчигдсөн эрхээ сэргээхийг шаарддаг болж, иргэдийн оролцоо нэмэгдэн, засаглалыг нээлттэй ил тод байлгахад хувь нэмрээ оруулдаг боллоо.

Улиастай: "Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний хэсгээс

Эрх зүйн хөтчид болон иргэдийн хамтарсан санаачилгууд хүрээгээ тэлж гэр хорооллын дахин төлөвлөлтөд өртөн орон гэргүй болсон өндөр настныг үнэ төлбөргүй өмгөөлж, нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн талд шийдвэр гаргуулсан, Завхан аймгийн эрх зүйн хөтөч нарын уйгагүй хүсэлт, шаардлагаар Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдэд нээлттэй болгуулсан, эрх зүйн хөтөч нар цахим орчинд үйл ажиллагаагаа явуулж чаддаг болсон зэрэг олон амжилт гарлаа.



"Эрх зүйн хөтөч нар-орон байртай байх эрх, нүүлгэн шилжүүлэлт" фэйсбүүк хуудсаар дамжуулан зорилтот бүлгийн иргэдэд зориулсан нийт 3763 мэдээ, мэдээлэл, зурагт хуудас бэлтгэжээ. Түүнчлэн орон байртай байх эрхийн талаарх мэдээ мэдээллийг давхардсан тоогоор зорилтот бүлгийн 185315 хүнд хүргэж, мэдээлэл түгээх сувгийг бий болголоо.

Завхан, Архангай аймаг болон нийслэлийн 6 дүүрэгт нийт 20 хөтөч ажиллуулах, орон байртай байх эрхийн талаарх мэдээллийг зорилтот бүлгийн **10000** хүнд хүргэж ажиллана гэсэн анхны зорилтыг олон үзүүлэлтээр давуулан нийт 25 шаардлага хангасан сертификаттай эрх зүйн хөтөч, сургалтад хамрагдсан цаашид хүний нөөцөд ажиллах боломжтой чадавхижиж байгаа эрх зүйн хөтчөөр ажиллах хүсэлтэй иргэдийн бүлэгтэй боллоо.

Орон байртай байх эрхийн 1/ **биет эрх зүйн хөтчийн тогтолцоо** (Байнгын цэг болон явуулын хөтөч нар ажиллах;); 2/ **цахим эрх зүйн хөтчийн тогтолцоо** (цахим хуудас, утас, чатаар зөвлөгөө, мэдээлэл өгөх)-г тус тус бий болгосноор дахин төлөвлөлтөд өртсөн иргэд хуулийг мэдэх, хэрэглэх, бүтээхэд оролцох боломжтой болов.

3. КОВИД-19 БА ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Ковид -19 цар тахлын эсрэг тэмцлийн хүнд ачааг эмч, эмнэлгийн ажилтнууд өнөөдөр нуруун дээрээ үүрсэн хэвээр байна. Гэвч нийгэмд тэдэнд талархахаас илүүтэйгээр буруутгасан, шүүмжилсэн, дарамталсан, биед нь халдсан, гадуурхсан хандлага гарах нь ихэссэнээс эмч, эмнэлгийн ажилтнуудын эрх зөрчигдөх, стресс, дарамтад өртөх, ажлын ачаалал, хүнд хэцүү ажлын нөхцөлөөс болж ажлаас халшрах, ажлын байраа орхисоор байна. Иймээс эмч, эмнэлгийн ажилтнуудад урам зориг, сэтгэлийн дэм өгөх захидал бичих аяны хүрээнд цугларсан 1000 орчим захидлаар бичил видео контент бэлтгэн хүргэлээ.

Дэлхийн эмч нарын өдрөөр “Эмч нарын эрх зүйн байдал” сэдвээр зохион байгуулсан хуралд оролцож Монголын Эмнести Интернэшнл байр суурьиа илэрхийлэхийн зэрэгцээ Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв, Мөнгөн гүүр эмнэлэг болон АШУИС-ийн захиралд иргэд олон нийт, гишүүд дэмжигчдийн бичсэн захидлуудыг тус тус хүлээлгэн өгөв. Мөн энэ үеэр “Ковид-19 ба Хүний эрх” шог зургийн үзэсгэлэнгээ дэлгэж олны хүртээл болгосон.

«Гэм зэм» жүжгийн үеэр

«Гэм зэм» жүжгийн үеэр

Орфэй театрын "Гэм зэм" жүжгийн үеэр Эрүүл мэндийн ажилтнуудад урам өгөх ил захидалд жүжигчид болон иргэдийг сэтгэлийн үгээ бичин оролцож буй нь.

4. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ДОРОЙТОЛ, МАЛЧДЫН ЭРХИЙН АСУУДАЛ

«Ярьдаг футболк» 2022

Цэвэр ус, газар, бэлчээр ашиглах, эзэмших болон уламжлалт өв соёл, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн үйл ажиллагаанаас төр малчдыг хамгаалж чадахгүй байгаа, хариуцлагагүй уул уурхайн олборлолт, тээвэрлэлт гэх мэтээс үүдэн иргэд, малчид бэлчээргүй, ундны цэвэр усгүй, эсвэл худгийн ус шавхагдсан зэрэг нь тэднийг орон нутагтаа амьдрах аргагүй байдалд хүргэсэн. Малчид орон нутгийн засаг захиргаандаа гомдол гарган асуудлаа шийдвэрлүүлэхээр удаа дараа оролдсоны эцэст 100 гаруй малчин Улаанбаатар хотноо ирж "Ярьдаг футболк" аянд нэгдлээ.

Нээлттэй нийгэм форум, Цагаан тоосны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах хөдөлгөөн ТББ болон Монголын Хуульчдын Холбоотой хамтран бид "Нийтийн эрх ашгийн өмгөөлөл: Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд" хэлэлцүүлэг зохион байгуулав. Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл явуулахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар байгаль орчин, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг эрдэмтэн, судлаач, хуульч, өмгөөлөгч, иргэний нийгмийн байгууллага, иргэд болон холбогдох төрийн байгууллагууд оролцсон уг хэлэлцүүлгээс зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр бүтээн босгох аливаа төсөл хөтөлбөрүүд хүний эрхийг зөрчихгүй байхад хувь нэмэр болно гэж үзэн Хамгааллын бодлогын шинэчлэлийн талаар иргэний нийгмийн байгууллагуудад мэдээлэл өгч, санал авах зөвлөгөөнд оролцон МЭИ-ийн байр суурийг танилцуулж, саналаа хэллээ.

Иргэний нийгмийн байгууллагуудын Европын Гадаад харилцааны албаны Ази, Номхон далайн бүсийн дэд захиралтай хийсэн уулзалтад оролцон иргэд, малчдын эдийн засаг, нийгмийн эрх тэр дундаа, Ковид-19 цар тахлын дараах эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийн болон хөдөлмөрлөх эрхийн талаар асуудал дэвшүүлж оролцов. Түүнчлэн Эмнести Интернэшнлийн Дэлхийн хүний эрхийн төлөв байдал тайланд Монгол улс дахь орон байртай байх эрх, эмч, эмнэлгийн ажилтны эрүүл мэндийн болон хөдөлмөрлөх эрх зөрчигдөж буй талаар гаргаж, дэлхийн нийтийн анхаарлын төвд оруулав.

Гарын үсэг зурж нэгдээрэй

Олон улсын хүний эрхийн асуудлуудад эв саналаа нэгтгэх, нөлөөлөх ажлын хүрээнд

Хөл бөмбөгийн Дэлхийн Аварга шалгаруулах тэмцээнийг 2022 онд Катар улсад зохион байгуулах цэнгэлдэх хүрээлэнг барих ажлыг ихэвчлэн Ази, Африк улсаас ирсэн цагаач ажилчид гүйцэтгэсэн, тэдний амьдрах нөхцөл, цалин хөлс тун муу, хэт олон цагаар ажиллаж, ажлын нөхцөл байдлын талаар гомдол гаргах, ажлаа солих эрхгүй байдалд байсан зэрэг хөдөлмөрийн мөлжлөгийг эсэргүүцэн Дэлхийн Хөл бөмбөгийн Холбоо, Катар дахь цагаач ажилчдын эрхийн асуудлыг хариуцсан байгууллагыг хариуцлага хүлээж, хариу үйлдэл үзүүлэх ёстой гэсэн олон улсын эв санааны нэгдлээ илэрхийлсэн цахим уриалгад нэгдэв.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭХИЙН ТӨЛӨӨ

ЗОРИЛТ

- *Хүмүүсийг хүний эрхийн талаар арга хэмжээ авах, мэдлэг, чадвар хандлагатай болгох,*
- *Хүний эрхийн боловсролоор дамжуулан оролцоог дэмжих,*
- *ХЭБ-ыг түгээх дотоод чадавхиа бэхжүүлэх*

ХЭЭС-ийн удирдах ажилтны уулзалт

Ковид-19 цар тахлаас үүдэн тасалдаад байсан уламжлалт Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн удирдах ажилтны уулзалт хийв. Уулзалтад Орхон, Булган, Дархан-Уул аймгийн болон нийслэлийн хүний эрхэд ээлтэй суургууль (ХЭЭС) сургуулиудын удирдлагууд оролцож, 118-р сургуулийн туршлагыг судлав. Оролцогчид өөрсдийн хүний эрхийн чиглэлээр хийж буй ажлаа харилцан танилцуулж, ХЭЭС хөтөлбөрийн үр нөлөөг сайшаахын зэрэгцээ цаашид хөтөлбөрийн үйл ажиллагааг сургуульдаа зохион байгуулж, хамтран ажиллана гэдгээ мэдэгдсэн. ХЭЭС хөтөлбөртэй холбоотой постер, мэдээлэл гарган 40700 гаруй хүнд цахимаар хүрсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийлээ. Үүнд:

- Нөхөрсөг жаалууд сургалт заах 29 сургагч багш бэлтгэж, тэднийг 5 удаагийн сургалтаар дадлагажууллаа. Тэнцэтгэлийг өөрчилье-Нөхөрсөг жаалууд сургалтыг Англи хэлний Академи, Томъёо, Хобби зэрэг хувийн хэвшлийн болон төрийн өмчит 30 сургуулийн 2417 сурагчид хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Түүнчлэн Англи хэлний Академийн 300 гаруй эцэг, эхэд Ковид-19 цар тахлын дараах хүүхдийн сэтгэл зүйн байдал болон нөхөрсөг жаалууд сургалтын талаар цахим сургалт хийлээ. Эмнести Интернэшнлийн хүний эрхийн академийг нөхөрсөг жаалууд сургалтын хүрээнд сурталчилж, тэднийг Ковид-19 ба хүний эрх сургалтыг монгол хэлээр төдийгүй дэлхийн олон хэлээр үзэж, судлахыг уриалав.

Нөхөрсөг жаалууд сургалт

«Ярьдаг футболк» 2022

- Монголын ЮНЕСКО-гийн холбоот 10 сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан зэрэг нийт 47 хүнд ХЭЭС-ийн танилцуулга болон Тэнцэтгэлийг өөрчилье сургалт хийж, туршлага солилцлоо.
- ХЭЭС хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэхээр Уудам Монгол, 85-р сургуулийн хамт олонд хүний эрхэд ээлтэй сургууль болох нь сургалт хийж, 60 орчим багш хамрагдлаа. Түүнчлэн ХЭЭС хөтөлбөрт хамрагдсан сургуулийн багш нарт Ковид-19-ийн дараах стрессийг даван туулах болон сурагчидтай хэрхэн харьцах талаар сэтгэл зүйн сургалт зохион байгуулав.
- Жил бүрийн 5-р сарын 28-ны өдөр зохион байгуулдаг Ярьдаг Футболк нээлттэй өдөрлөгт ХЭЭС хөтөлбөрийн сургуулиуд идэвхтэй оролцож, хүний эрхийн мессеж бүхий богино цамцаараа гоёцгоон хүний эрхийн төлөөх аянд нэгдэцгээв. Монгени цогцолбор сургууль, Логарифм, Шинэ эхлэл, 12, 3, 51, 118 зэрэг Хүний эрхэд ээлтэй сургуулийн баг хамт олон хүүхдийн эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, сурч боловсрох эрх, ялгаварлан гадуурхалт, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, уур амьсгалын өөрчлөлт-байгаль эх дэлхийгээ хайрлах болон ирээдүй хойчийн эрхийн тухай мессеж түгээн оролцов.

УР ЧАДВАРЫН УРАЛДААН

Монголын Эмнести Интернэшнлээс санаачлан ХУД-ийн Боловсролын хэлтэс, ХУД-ийн 118-р сургуультай хамтран ЕБС-ийн багш нарын дунд жил бүрийн Олон улсын Хүний эрхийн өдрийг угтан зохион байгуулдаг "Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь" XII дугаар тэмцээнд Завхан, Орхон, Булган аймаг болон нийслэлийн 32 багш хичээл зааж ур чадвараа сорилоо. Анх удаа орон нутгаас 16 багш хүрэлцэн ирсэн онцлогтой жил боллоо.

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 1-р сургуулийн багш С.Мөнхбаатар, Монте Роза Шүлэ сургуулийн багш Т.Үржинбадам болон Орхон аймгийн 13-р сургуулийн багш Г.Энх-Амгалан нар эхний гурван байрт шалгарч, Тусгай байрын эздээр Наран 1-р сургуулийн багш С.Соёлмаа, БЗД-ийн 14-р сургуулийн багш Э.Солонго, ХУД-ийн 32-р сургуулийн багш Г.Дагмидмаа нар тус тус тодорч, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнуулав.

Уралдаанд багш нар математик, монгол хэл, нийгэм, иргэний ёс зүй, англи хэл, биологи, хүн ба нийгэм, түүх, газар зүй, технологи, дүрслэх урлаг зэрэг 11 хичээлээр тэр дундаа түүх, нийгмийн ухааны хичээлээр түлхүү заасан. Хүний эрхийн агуулга, үзэл санааг тусгасан энэ хичээлүүдээр сайн хичээлийн сангаа баяжуулсан мөн анх удаа орон нутгаас зорьж ирсэн 2 залуу багш тэргүүн, гутгаар байрт шалгарсан онцлогтой уралдаан болов.

Уралдааны үеэр "Хүний эрх, эрх чөлөө" шог зургийн үзэсгэлэнг 118-р сургууль дээр толилуулж урлагаар дамжуулан ээлжит хичээлээрээ 20 гаруй багш, 1123 гаруй сурагч хүний эрхийн боловсрол олж авсан байна.

Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь» XII дугаар тэмцээн

Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь» XII дугаар тэмцээн

ХЭЭС-ИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТЭТГЭЛЭГТ УРАЛДААН

Хүний эрхэд ээлтэй сургуулиудыг дэмжих зорилгоор олон улсын хүний эрхийн өдрийг угтсан үйл ажиллагаа сургуульдаа явуулах төслийн уралдааныг зарлаж, нийслэлийн болон орон нутгийн 11 сургууль төслөөс Шинэ эхлэл сургуулийн "Эмнеститэй хамт -7 хоног", Баян-Өлгий аймгийн 2-р сургуулийн "Тэнцэтгэлийг өөрчилье" , Сүхбаатар аймгийнн 2-р сургуулийн "Ye тэнгийн дарамт, дээрэлхэлгүй маргааш" төсөл тус тус шалгарлаа. Дээрх сургуулиуд сургуулийн орчинд дээрэлхэлтээс урьдчилан

ХЭЭС-ийн хүний эрхийн тэтгэлэгт уралдаан

сэргийлэх, мэдээлэл авах тухай журам боловсруулах, энэ сэдвээр багш нарын хичээл заах ур чадварын уралдаан, ханын сонин гаргах зэрэг үйл ажиллагаа зохион байгуулсан нь ойролцоогоор 3000 гаруй багш, сурагчид хүрчээ.

Философи-хүний эрхийн уулзварт

ФИЛОСОФИ-ХҮНИЙ ЭРХИЙН УУЛЗВАРТ

Философи-хүний эрхийн уулзварт улсын 14 дүгээр олимпиадыг "Технологийн ёс зүй ба хүний эрх" сэдвээр, ШУТИС ерөнхий зохион байгуулагчаар ажиллав. МУИС-ийн харьяа Ховд Их сургуулийн баг зэрэг 15 Их, Дээд сургуулийн философийн хичээл судалж буй 75 оюутан Философичдын хүний эрх, философийн үзэл баримтлалд онолын шинжилгээ хийж, хүний эрхийн мэдрэмжтэй, философи эргэцүүлэл дээшлүүлж, оюун ухаанаа өрсөлдүүлснээс МУИС, ШУТИС, Отгонтэнгэр Их сургууль тус тус эхний гурван байранд шалгарч, СЭЗИС тусгай байрт орсон.

Техник, технологийн шинэ эринд нийгмийн хөгжил нь хурдацтайгаар өргөжин тэлж байгаа хэдий ч дэлхий даяар үзэл бодол, шашин шүтлэг, соёл, уламжлалын ялгаа, тэгш бус байдлаас үүдэлтэй хүний эрхийн зөрчил техник, технологийн хэрэглээнээс үүдэн нэмэгдэж байгаа энэ үед "Технологи-Хүний эрх- Ёс зүй"-н асуудал нь цагаа олсон ажил юм. Олимпиадаар "Цахим ёс зүй", "Экологийн ёс зүй", "Боловсролын технологи", "Наноэтик", "Цэргийн техник", "Биотехнологийн ёс зүй" болон "Инженерийн ёс зүй" зэрэг дэд сэдвийг нарийвчлан оруулсан нь техникийн хөгжил хэрхэн байгаль, экологи, нийгэм, эдийн засагт эерэг, сөргөөр нөлөөлөх болон хувь хүний жам ёсны эрхтэй хир нийцэж байгааг эргэцүүлэн, ёс суртахууны философийн үүднээс үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бий болгосон байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ЭМНЕСТИГИЙН ЗАЛУУЧУУД

ЗОРИЛТ

- *Эмнести Интерэншнлийн хүний эрхийг хамгаалах ажлын гол төвд хүүхэд, залуучуудын үзэл санаа, байр суурийг тусгах*
- *Хүүхэд, залуус Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааны бүх түвшинд идэвхтэй, манлайлан оролцох бололцоог хангах*
- *Эмнести Интернэшнлийн гишүүн, дэмжигч, идэвхтэн хүүхэд залуусын тоо нэмэгдэж, нийгмийн олон талт бүлгүүдийг хамран оролцуулах*

Эрхээ мэдье 2022

ХҮҮХЭД, ЗАЛУУС ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД:

Монголын Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөлд залуу гишүүн ажиллаж, залуусын үзэл санаа, байр суурийг төлөөлж, шийдвэр гаргах түвшинд тогтмол хүргэж байна. 2022 онд удирдах зөвлөлийн залуучууд хариуцсан гишүүн, хяналтын зөвлөлийн залуу гишүүн, залуучуудын бүлгийн ахлагчдаас бүрдсэн Залуучуудын зөвлөл байгуулагдаж, залуучуудыг хүний эрхийн үйл ажиллагаанд татан оролцуулах шинэ санаа, санаачилга гарган, тогтмол уулзалтуудыг зохион байгуулаа.

Залуу гишүүн У.Мичидгэрэл Эмнести Интернэшнлийн дэлхийн чуулганд Монгол улсаа төлөөлөн оролцож, дэлхий дахинд тулгарч буй хүний эрхийн асуудлаар үр дүнтэй ажиллах талаар ярилцлаа. Мөн 10 залуу гишүүн Эмнести Интернэшнлийн Ази номхон далайн бүсийн төвийн хүний эрхийн активизм өрнүүлэх уулзалтад оролцож, өөрсдийн туршлагаа хуваалцсан.

Эмнести Интернэшнлийн 2022 онд шинээр эхлүүлж буй тайван замаар хуран, цуглах эрхийг хамгаалах "Жагсагчдыг хамгаал" кампанит ажлыг төлөвлөх, Ази-Номхон далайн бүс нутагт уг кампанит ажлыг хэрхэн зохион байгуулах талаар санал солилцох 4 удаагийн уулзалтыг зохион байгуулж, 90 орчим залуу гишүүд саналаа хуваалцлаа.

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН СТРАТЕГИ 2022-2025

ХҮҮХЭД, ЗАЛУУС БОДЛОГЫН ТҮВШИНД:

Монголын Эмнести Интернэшнлийн залуу гишүүд 2022 оны 2-р сарын 21-ний өдрөөс эхлэн нийт 7 сарын турш дотоод болон гадаад үнэлгээ, залуу гишүүд дунд судалгаа, асуулга, ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэн хэлэлцсэний үр дүнд 2022-2025 оны стратегиа боловсруулан бэлэн болголоо. Стратеги нийт 5 зорилтын хүрээнд залуусын хүний эрхийг хамгаалах үйлсэд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, тэдний үзэл бодлыг бодлогын түвшинд тусгах, бусад залуусын хөдөлгөөн, байгууллагатай хамтын ажиллагаа сайжруулах зэрэг чухал асуудлуудыг тусган, алсын хараагаа тодорхойллоо.

ХҮҮХЭД, ЗАЛУУС ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮХ ТҮВШИНД ИДЭВХТЭЙ, МАНЛАЙЛАН ОРОЛЦОХ БОЛОЛЦООГ ХАНГАХ

Залуу гишүүдийн хүний эрхийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний эрхийн активизм өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хүний эрх энгийн үгээр" цуврал хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Эхний хэлэлцүүлгийг 6-р сарын 04-ны өдөр буюу Таньяньмэний талбайд болсон хэргийг дурсах өдрөөр зохион байгуулж, залуу гишүүд инстаграм орчинд эв санааны нэгдлээ илэрхийлэх цахим давлагаад нэгдсэн байна. Мөн 6-р сарын 20-ны өдөр Эмнести Интернэшнлийн Орос Украины хэрэгт хийсэн дүн шинжилгээ, тайланг танилцуулж, ярилцах уулзалтыг зохион байгууллаа.

Уг уулзалтын үр дүнд залуус Эмнести Интернэшнлийн Украины хямралын санд хандив босгох санаачилга гаргаж, хэрэгжүүлсэн байна.

Жил бүрийн залуучуудын өдрөөр зохион байгуулагддаг Иргэний нийгмийн залуучуудын чуулганд Монголын Эмнести Интернэшнлийн залуу гишүүд оролцож, шийдвэр гаргагчдад хүргүүлэх чуулганы зөвлөмжид саналаа тусгалаа. Мөн МЭИ-ийн зохицуулагч Г.Сүхбат илтгэгчээр оролцож, иргэний орон зайг хамгаалах тухай мэдлэг, туршлагаа хуваалцав.

Монголын Эмнести Интернэшнл 2022 онд нийт 358 хүний эрхийн үйл ажиллагаа зохион байгуулж 790 000 орчим хүн оролцсоноос 52% нь 34 хүртэлх насны хүүхэд, залуус байна.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ КАМПАНИТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХҮҮХЭД, ЗАЛУУС

Хүний хувийн халдашгүй байх эрх, хувийн нууцтай байх эрх, хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах талаар олон нийтэд мэдээлэл түгээх зорилготой "Нууц шүү за" аяныг үргэлжлүүлэн, хүрээг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллалаа. Залуу гишүүд хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн талаар судалж, харилцагчдынхаа хувийн мэдээллийг цуглуулдаг 100 байгууллагыг хамруулсан судалгаа хийж, үр дүнг танилцуулсан нөлөөллийн ажлыг бэлтгэлийг хийлээ.

Өмгөөлөгчдөд хийсэн сургалтын үеэр

Мөн аяны агуулгыг түгээх, хүний эрх хамгаалагчдын цахим аюулгүй байдлын талаар мэдлэгийг дээшлүүлэх талаар "Цахим аюулгүй байдлаа хангах нь" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Монголын төрийн бус байгууллагуудын хүний эрхийн форумын гишүүд, хүний эрх хамгаалагчийг өмгөөлөх өмгөөлөгчид, орон нутгийн хүний эрх хамгаалагчид зэрэг нийт 50 орчим хүнийг сургалтад хамруулаа.

Хүний эрх хамгаалагчийг хамгаалах "Зоригтон" кампанит ажлыг хүрээнд жил бүр зохион байгуулдаг "Хүний эрх хамгаалагч залуучууд" зуны зуслан сургалт зохион байгуулж, 24 манлайлагч залуу хамруулаа. Залуучууд хүний эрхийн үндсэн ойлголтоо нэмэгдүүлж, хүний эрхийн нөлөөллийн ажил өрнүүлэх, активизм зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах, мониторинг хийх чадваруудад суралцаж, уур амьсгалын өөрчлөлт, тайван замаар хуран цуглах эрх, орон байртай байх эрх зэрэг сэдвээр бичил төсөл санаачлан хэрэгжүүлж байна.



Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлснийхээ улмаас эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн төлөө захидал бичих «Эрхийнхээ төлөө бичицгээе» аяныг зохион байгуулахад 50 гаруй залуу гишүүд оролцож, МУИС, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг их сургууль, ДХИС, Их засаг их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Томүжин, Улаанбаатар Эмпати, Орчлон, 11-р сургууль, Эм Аи Юу, Монгени, Нэст ахлах сургууль зэрэг 14 сургуульд захидал бичих аяныг өрнүүлж нийт 23 000 орчим гарын үсэг цуглуулж, илгээлээ.

Монголын залуучуудын өдрийг угтан Монголын Эмнести Интернэшнлийн сайн дурын ажилтнууд, манлайлагч залуу гишүүд өөрсдийн санаа зовж буй хүний эрхийн асуудал, түүнийг даван туулах шийдлийн талаар үзэл бодлоо цахим орчинд хуваалцаж, үе тэнгийн залуустаа уриалга хүргэлээ.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН КАМПАНИТ АЖЛЫН ХҮРЭЭНД ХҮҮХЭД, ЗАЛУУС

ЕБС-иудад зориулсан үе тэнгийн шоглох, дээрэлхэх, дарамтлахын эсрэг "Нөхөрсөг жаалууд" сургалтын 29 залуу сургагч багш бэлтгэгдлээ. Сургагч багш нар нь бага насны хүүхдийн насны онцлогт хэрхэн тохируулан харилцах талаар болон бага насны хүүхдэд хичээл заах аргазүй, аливаа зөрчлийг зөвөөр зохицуулах арга болон шоглох, дээрэлхэхийн талаар цогц сургалтад хамрагдаж, нийт 30 сургуулийн 2417 хүүхдэд хүний эрхийн боловсрол олгожээ.

Нөхөрсөг жаалууд сургалт

Дэлхийн дахинаа Эмнести Интернэшнл хөдөлгөөн үүссэн өдрийг угтан жил бүр зохион байгуулдаг "Ярьдаг Футболк" өдөрлөгийг төлөвлөх, зохион байгуулах ажил 30 гаруй залуу гишүүд манлайлан оролцож, нийт 1800 гаруй хүнд үе тэнгийн дээрлэхэлт, уур амьсгалын өөрчлөлт, технологи ба хүний эрх, орон байртай байх эрх зэрэг кампанит ажлуудын талаар мэдээлэл хүргэжээ.

Ярьдаг футболк 2022

Сурагчдын бүлгийн сан арвижуулах арга хэмжээ

САН АРВИЖУУЛАЛТ БОЛОН БҮСАД АЖИЛД ХҮҮХЭД, ЗАЛУУС

Эмнести Интернэшнлийн хүний эрхийн төлөөх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор залуу гишүүн сан арвижуулах үйл ажиллагааг тогтмол санаачлан зохион байгуулж байна. 2-р сарын 12-ны өдөр Монголын Эмнести Интернэшнлийн сурагчдын бүлгийн санаачилгаар "Surprise box" урлан сан арвижуулах арга хэмжээ зохион байгуулагдлаа. Мөн залуу гишүүд хуучин ном хандивлах аяныг 3 сарын хугацаагаар зохион байгуулж, номын худалдаа явуулж сан арвижуулан Эмнести Интернэшнлийн Украины хямралын санд хандив өргөлөө. Гадаадын тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар үе тэнгийн залуустаа мэдээлэл түгээж, сан арвижуулах өдөрлөгийг залуу гишүүд санаачлан зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хүний эрхийн үйл ажиллагаанд татан оролцуулах, тэднийг хүний эрхийн төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой 10 хүний эрхийн клуб тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Хүний эрхийн клубын гишүүн сурагчид Ярьдаг Футболк, Хүний эрхэд ээлтэй сар зэрэг залуучуудын үйл ажиллагаанд оролцохоос гадна хүний эрхийн бичил арга хэмжээ санаачлан хэрэгжүүлдэг.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ГИШҮҮН, ДЭМЖИГЧ, ИДЭВХТЭН ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ТОО НЭМЭГДЭЖ, НИЙГМИЙН ОЛОН ТАЛТ БҮЛГҮҮДИЙГ ХАМРАН ОРОЛЦУУЛАХ

Монголын Эмнести Интернэшнлийн нийт гишүүд, дэмжигчдийн 60% гаруй хувийг 34 хүртэлх насны залуу гишүүд эзэлдэг бөгөөд сурагчид, оюутнууд, залуучуудын бүлгүүд болон сан арвижуулалт, хүний эрхийн боловсрол, үйл ажиллагаа, активизм, дижитал хариуцсан багуудад хуваагдан хүний эрхийн үйл ажиллагаанд оролцдог.

Хүний эрхийг хамгаалах үйлсийг хүүхэд, залууст таниулах, Монголын Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 10-р сарыг "Хүний эрхэд ээлтэй сар" болгон зарлаж, гишүүн өргөжүүлэх үйл ажиллагааг МУИС, МҮИС, Их засаг, СЭЗИС, ШУТИС, Шихихутуг зэрэг сургуулийн 900 гаруй залуусыг хамруулан зохион байгууллаа.

Сайн дурын ажлыг сурталчлах, залуусыг сайн дурын ажилд татан оролцуулах зорилгоор I volunteer, do you? өдөрлөгт оролцож, хүүхэд залууст мэдээлэл хүргэсэн байна. 7-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан "Сайн дурын ажил ба Нийгмийн хариуцлагад залуусын оролцоо" хэлэлцүүлэгт залуучууд хариуцсан зохицуулагч Б.Тэргэл илтгэгчээр оролцож, 170 гаруй залууст МЭИ-ийн үйл ажиллагаа, сайн дурын ажилтнуудын хүний эрхийг хамгаалахад оруулж буй хувь нэмрийн талаар танилцууллаа.

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ

ЗОРИЛТ

- *Өөрсдийн нөөц бололцоо, оролцоог хамгийн дээд түвшинд хүргэх*

Бүх гишүүдийн 3-р улирлын уулзалтын үеэр

1. ГИШҮҮД БОЛОН ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

358
үйл ажиллагаа

23,184
идэвхтэн

787,769
дэмжигч

138
Хамтрагч байгууллагууд

382
сайн дурын ажилтан

13,606 цаг
хүний эрхийн төлөө зарцуулжээ.

2. УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ, БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

- Удирдах Зөвлөл /УЗ/ нийт 7 удаа хуралдаж, 24 тогтоол, шийдвэр гаргаснаас ихэнх буюу 95%-ийн биелэлттэй байна. Хяналтын Зөвлөл /ХЗ/ 2 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. Түүнчлэн УЗ цаг үеийн хүний эрхийн асуудлуудад түргэн шуурхай хариу арга хэмжээ авч ажиллалаа.
- Байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэх хүрээнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг сургалтыг УЗ, ХЗ, Гүйцэтгэх товчоонд орж, байгууллагын бүхий л дүрэм, журам, бодлогыг шинэчлэхээр ажлыг эхлүүлээд байна.

Бүх гишүүдийн 1-р улирлын уулзалтын үеэр

3. ГИШҮҮН ӨРГӨЖҮҮЛЭЛТ, ЧАДАВХЖУУЛАХ

- Шинэ гишүүдэд байгууллагын үнэт зүйл, үйл ажиллагааны тухай ойголтыг өгөх шинэ гишүүний сургалтыг цахим болгож, гишүүдээ чадавхжууллаа.
- Бүлэг, гишүүдийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлт ба хүний эрх, COP27 хурал ба Эмнестигийн байр суурь, Төсөв ба хүний эрх, Дүрвэгч, цагаач ажилтан, орогнол хайгчийн эрх, 2022 оны 01 сарын 01-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хуулиудын сургалт зэрэг бодлогын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, бодлого боловсруулахад болон гишүүдийн олон талт оролцоог ханган ажиллалаа.
- Ажилтнууд, манлайлагч гишүүд чадавхи бэхжүүлэх сургалтуудад тухайлбал: Жагсаал, цуглааны ажиглагчийн сургалт, Олон улсын төвийн төсөв ба хүний эрхийн сургалтууд, Сан арвижуулалт, цахим аюулгүй байдал, Хүний эрхийн үл нөлөө, Хүний эрх хамгаалгчийн эсрдэлийн үнэлгээ, Хүний эрхийн Мониторинг хийх нь зэрэг олон улсын болон дотоодын олон сургалтуудад хамрагдаж чадавхи бэхжүүллээ.
- Сайн дурынханд МЭИ-ийн үйл ажиллагаанд цахим болон цахим бусаар ажиллах боломжийг бий болгохын зэрэгцээ гишүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа, хэлэлцүүлгүүдэд хамруулан чадавхжууллаа.
- Энэ жил 5 оюутан дадлагажиж, хүний эрхийн төлөө үйл ажиллагаанд гар бие оролцож, ур чадвар, хүний эрхийн ойлголтоо нэмэгдүүллээ.
- Бүх гишүүдийн уулзалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 250 орчим гишүүн оролцож, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх эрх, иргэний орон зайг хамгаалахын төлөө дуу хоолойгоо нэгтгэхээс гадна Украйны хямралын санд хандив өргөх зэрэг сан арвижуулалт хийлээ.

ОРОН НУТГИЙН БҮЛГҮҮД

Орон нутгийн бүлгүүд идэвхжиж, бие даан үйл ажиллагаа зохион байгуулдаг болов. Тухайлбал; Архангай, Баян-Өлгий, Завхан, Дархан-Уул, Орхон зэрэг 5 аймагт Ярьдаг футболк өдөрлөг, эрхийнхээ төлөө бичицгээе аян тус бүр зохион байгуулагдаж, **14.000** гаруй хүнд хүний эрхийн боловсрол олгож, захидал уриалгад **9.000** гаруй гарын үсэг зуруулж, Завхан, Архангай аймагт Орон байртай байх эрхийн эрх зүйн хөтчийн байнгын цэг ажиллав.

«Ярьдаг футболк 2022» Дархан-Уул аймагт

4. БАЙГУУЛЛАГЫН САЙН САЙХАН БАЙДАЛ (WELLBEING)

- Байгууллагын сайн сайхан байдал буюу Wellbeing нь дөрвөн тулгуур ойлголт бөгөөд ажлын туршлагатай холбогдон бий болсон хувь хүний хэрэгцээг харуулдаг. Wellbeing-д бие махбод, сэтгэл хөдлөл, сэтгэлзүйн байдлыг л хамааруулан ойлгодог ч аюулгүй байдал, амьдралын баталгаа, ажиллах орчин, сэтгэл ханамж, ажлын зорилго, утга учир ба ажил дээрх сэтгэл зүйн эрүүл мэнд бүгд багтана. 2022 онд тусгай төлөвлөгөөний дагуу бид хүний эрхийн идэвхтэн, гишүүд, ажилтнууд, УЗ, ХЗ-ийн гишүүд, манлайлагч гишүүдийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр ажиллав.
- Өөрсдийнхөө сайн сайханд анхаарахаас гадна Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 50 гаруй байгууллагуудын нэгдсэн Хүний эрхийн форумын гишүүдийн сэтгэл зүйн түгшүүр, стрессийг бууруулах зөв дадлыг бий болгохоор сайн сайхан байдлыг сургалт, цахим аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулаа.

Бид 2022 онд оролцоотой, олон талт, шилдэг сайн дурын менежменттэй, стресс бухимдалгүй, илүү олон идэвхтэн, дэмжигчдийг дайчилсан байгууллага боллоо.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Баталгаажуулсан:.....С.Ганчимэг /Удирдах зөвлөлийн дарга

САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2022 IV УЛИРАЛ

Монголын Эмнести Интернэшнл

Санхүүжилт 2022	Санхүүжилт /ам.доллар/	
	Төсөвлөсөн	Гүйцэтгэл
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт	3,500.00	827.76
Тогтмол бус хандив	2,800.00	2,635.78
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт	28,750.00	17,623.27
Бусад сан арвижуулалт	15,367.00	4,752.37
Гишүүдийн татвар, сан арвижуулалт, хандивын тогтмол санхүүжилт		**25,839.18**
ОУТөвийн санхүүжилт	195,238.00	223,244.78
НИЙТ САНХҮҮЖИЛТ	**245,655.00**	**249,083.96**

Зарцуулалт 2022		Зарцуулалт /ам.доллар	
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 2	139,822.00	118,621.99
Өсөлтийн стратегийн зорилт	Сан арвижуулах	18,619.00	14,247.56
	Бусад асуудал	34,729.00	22,130.42
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		9,137.00	7,641.50
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны зардал		43,348.00	55,567.76
Нийт зардал		**245,655.00**	**218,209.23**

Эхний үлдэгдэл		
Бэлэн мөнгө (Касс болон банк)	57,158.82	
Нөөцийн сан	75,638.74	
Урьдчилж төлсөн төлбөр	4,566.53	
Авлага	40,885.36	
Өглөг	42,681.65	
Эцсийн үлдэгдэл		
Бэлэн мөнгө (Касс болон банк)		68,416.11
Нөөцийн сан		96,879.81
Урьдчилж төлсөн төлбөр		6,185.67
Авлага		199.64
Өглөг		5,238.70

Тайлан хянасан: Б. Алтантуяа
Гүйцэтгэх захирал

Тайлан хянасан: Б.Мөнхжавхлан
Удирдах зөвлөлийн гишүүн, Санхүүч

Тайланг бэлтгэсэн: У. Наранцацрал
Санхүүгийн ажилтан

УЛААНБААТАР ХОТ
Аудит хийсэн : Б.Өлзийзаяа
Нийслэл Аудит ХХК-ны Аудитор
НИЙСЛЭЛ АУДИТ ХХК
ТТГ4872 ☎ 5009756

NIISLEL-AUDIT LLC
CERTIFIED ACCOUNTING
AUDIT & APPRAISAL

2022 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: Ухнаагийн Хүрэлсүх (6 дугаар сард Халтмаагийн Баттулгын дараа сонгогдсон)
Засгийн газрын тэргүүн: Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ

Ковид–19 цар тахлын хязгаарлалтыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар хуран чуулах эрхийг нухчин дарахад хэрэглэсэн. Эрүүл мэндийн ажилтнууд хөдөлмөрийн тааруу нөхцөлөө эсэргүүцсэнийхээ төлөө заналхийлэл, доромжлолд өртсөн. Эрх баригчид эрүүдэн шүүгдсэн гэх хэргийг үр дүнтэй шийдвэрлэж чадсангүй.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

2021 онд Ковид-19 цар тахлын эсрэг авсан Засгийн газрын хариу арга хэмжээний ихэнх нь хүмүүсийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байгааг эсэргүүцсэн 200 гаруй жагсаал, цуглаан болсон.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ХУРАН ЧУУЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Ковид-19 цар тахлын тархалтыг хянахын тулд тогтоосон хязгаарлалтууд жагсаал, цуглаан хийхийг хориглосон нь тайван замаар хийсэн жагсаал, эсэргүүцлийг дур зоргоор, заримдаа хүч хэрэглэн тараах шалтаг болсон. Зарим жагсаал цуглаан зохион байгуулагчдыг баривчилж, хорьж, торгууль ногдуулжээ.[1]

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ЭРХ

Ковид-19 цар тахал эрүүл мэндийн ужгирсан тогтолцооны сул талыг улам ил болголоо. Цар тахлын эсрэг тэргүүн эгнээнд тэмцсэн эрүүл мэндийн зарим ажилтан эрх баригчдын дарамтад өртжээ. Түүнчлэн бухимдсан өвчтөнүүд эмч, сувилагчдын биед нь халдах, гутаан доромжлох нь ихэссэн. Эрүүл мэндийн ажилтнууд эрхийнхээ төлөө тэр дундаа ажлын ачаалал, хөдөлмөрийн тааруу нөхцөл, цалин хөлс болон өвдөж, ядарсныг нь үл тоох харилцаа, хандлагыг эсэргүүцэн жагссан нь Ерөнхий сайдын сүрдүүлэгт өртөв.

Хэдийгээр биеийн байдал нь муу байсан ч эрүүл мэндийн олон ажилтан ажлаа алдахаас айж ажилласаар байв. 10 дугаар сарын байдлаар таван эрүүл мэндийн ажилтан тутмын нэг нь Ковид-19-ийн халдвар авчээ.

СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэхээр Засгийн газраас бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг хаасан нь малчин өрхийн болон хотын захын эсвэл зурагтгүй, интернэтийн сүлжээгүй газар амьдардаг хүүхдүүдийн сурч боловсрох эрхэд сөргөөр нөлөөлсөн. 9 дүгээр сард бараг 2 хичээлийн жилийн дараа сургуулиуд эргэж танхимаар хичээллэв.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ

7 дугаар сард Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Уг хууль нь хүний эрх хамгаалагчийн хамгаалалтыг бэхжүүлсэн ч, хүний эрх хамгаалагчийн дуу хоолойг дур зоргоор хязгаарлах, тэдэнд эрүүгийн хэрэг үүсгэх эрсдэлийг бий болгох заалтууд агуулсан байна. Газрын эрх, хүрээлэн буй орчны асуудлаар ажилладаг малчид, өмгөөлөгчид зэрэг эрхийн төлөө тэмцэгчид дарамт шахалт, заналхийлэлд өртөж, хууль ёсны үйл ажиллагааныхаа төлөө мөрдөн шалгагджээ.[2]

ЭРҮҮДЭН ШҮҮХ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Монгол Улс НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгээс өгсөн холбогдох зөвлөмжийг хүлээн авсан ч 2020 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах тухайд ахиц дэвшил гаргасангүй. Эрүү шүүлтээс амьд үлдэгсэд, хохирогчдын гэр бүлийнхэн үр дүнтэй, бүрэн нөхөн төлбөр авч чадахгүй байна. Эрүүдэн шүүсэн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ихэнхдээ хэрэгсэхгүй болж, хариуцлага хүлээх ёстой этгээдийг шүүхээр оруулах нь ховор байна. 10 дугаар сард Прокурорын Ерөнхий Газраас өгсөн тоон мэдээллээр эрүүдэн шүүсэн гэх 53 хэргийг хянаснаас ердөө 3 хэргийг шүүхэд шилжүүлжээ.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН АСУУДАЛ

Төрөөс "иргэдийн төлөөллийн байгууллага" байгуулахад саад болсоор байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд иргэдийн төлөөллийн байгууллага нь иргэдийн газар, орон байртай байх эрхийг хөнддөг дахин төлөвлөлтийн төсөл өмчлөгч, эзэмшигчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах үүрэгтэй.

2018 онд нийслэлийн Баянгол дүүрэгт дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч компани Пунцагийн Даваанаям болон түүний гэр бүлийг албадан нүүлгэж, байшинг нь нураасан хэргийн гомдлыг 10 дугаар сард Улсын дээд шүүх хэрэгсэхгүй болгосон.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Нийслэлийн Засаг даргын орлогчийн 9 дүгээр сард нийгмийн сүлжээнд нийтэлсэн ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан пост нь ЛГБТИ хүмүүс, идэвхтэн болон тэдний эрхийг хамгаалдаг байгууллагыг заналхийлэх, үзэн ядах үг илэрхийлэл ихсэхэд хүргэсэн байна.

---

[1] Монгол улс: Тайван замаар хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг нухчин дарж байна, www.amnesty.mn

[2] Хүний эрх хамгаалагчийн бодит нөхцөл байдал бэрхшээл, www.amnesty.mn

Эмнести Интернэшнл нь хүн бүрт эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа улс төрийн үзэл баримтлал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байж, гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, #АВ центрийн 11 давхар 1101 тоот
Утас/Факс: 976-7000-4705
members@amnesty.mn
www.amnesty.mn

ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЕ

БИД ЯМАР ЭРХТЭЙГЭЭ ЗААЛГАХ ЭРХТЭЙ